



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/187

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалт, 3 дугаар хэсгийн 3.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Хот байгуулалтын дундын мэдээллийн сан, Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй ажлуудын мэдээлэл, тэдгээрийн уялдаа холбоо, өгөгдлийг Иргэдийн оролцоотой газрын зураглал /manaikhогоо.mn/-ын системийн дата мэдээлэлтэй нэгтгэн, ArcGis буюу газар зүйн мэдээллийн системд шилжүүлэх, системийг шинээр хөгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл боловсруулах, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Э.Энхцэцэг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга;
Гишүүд:	О.Чинзориг	Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын дарга;
	Н.Батбилэг	Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын Системийн хөгжүүлэлтийн хэлтсийн дарга;
	Э.Батжаргал	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтсийн Дотоод хяналтын ахлах мэргэжилтэн
	Г.Цогтдэлгэр	Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын Орон зай, дундын мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн;
	Т.Бахытгүл	Азийн сангийн Төслийн ахлах ажилтан;


D:\backup_old_pc\Work documents\doc 2019\Тушаал doc.docx

1110300527

Нарийн бичгийн С.Эрдэнэболд
дарга:

Улаанбаатар хотын Захирагчийн
ажлын албаны Захиргаа,
санхүүгийн хэлтсийн мэдээллийн
технологийн асуудал хариуцсан
мэргэжилтэн;

2. Дээрх системийг ArcGis буюу газар зүйн мэдээллийн системд шилжүүлэх
ажлын үр дүн, явцыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерт танилцуулахыг Ажлын
хэсэг /Э.Энхцэцэг/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

